



## БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 17 өдөр

Дугаар АБ7

Булган сум

Г Баруун бүсийн өвлийн аялал жуулчлалын Г  
эвент арга хэмжээнд оролцож, туршлага судлах  
аяллыг зохион байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ховд аймгийн Хар ус нууранд зохион байгуулагдах "Мөнгөлөг шагшуурга-2024" баруун бүсийн өвлийн аялал жуулчлалын эвент арга хэмжээнд зарим төрийн албан хаагчдыг оролцуулсугай.


2. Баруун бүсийн өвлийн аялал жуулчлалын эвент арга хэмжээнд оролцож, туршлага судлах аяллын удирдамжийг хавсралтаар баталсугай.

3. Дээрх арга хэмжээнд шаардагдах 9,428,400 (есөн сая дөрвөн зуун хорин найман мянга дөрвөн зуу) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс санхүүжүүлэхийг Засаг даргын тамгын газрын дарга (Д.Алтаншагай)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

Б.АРИУН-ЭРДЭНЭ





**Баруун бүсийн өвлийн аялал жуулчлалын эвент арга хэмжээнд  
оролцож, туршлага судлах аялалын удирдамж**

**Нэг.Зорилго.**

Монгол Улсын Засгийн газраас “2023-2025 онын Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Ховд аймагт зохион байгуулагдах олон угсаатны соёлын өвийг таниулан сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, үндэсний соёлын өвөөрөө бахархаж, үзэсгэлэнт байгаль дэлхийгээ хайрлан хамгаалах, өвлийн аялал жуулчлал, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх “Мөнгөлөг шагшуурга-2024” Хар ус нуурын мөсний эвент арга хэмжээнд оролцон туршлага судлах аялалыг зохион байгуулна.

**Хоёр.Хамрах хүрээ**

Аймгийн Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс, Соёл урлагийн газар, Хөгжимт жүжгийн театрын албан хаагчид оролцоно.

**Гурав.Хугацаа**

2024 оны 01 дүгээр сарын 18-ний өдрөөс 2024 оны 1 дүгээр сарын 23-ний өдөр хүртэлх.

**Дөрөв.Аяллын маршрут**

Булган сум-Рашаант сум-Өвөрхангай аймаг-Архангай аймаг-Баянхонгор аймаг-Ховд аймаг-Баянхонгор аймаг-Архангай аймаг-Өвөрхангай аймаг-Рашаант сум-Булган сум

**Тав.Тооцоолол**

Туршлага судлах аяллын маршрут (нэг талдаа)

Д/д	Аяллын маршрут явуулах чиглэл	Явах замын хэмжээ /км/	Хугацаа
1	2	3	4
1	Булган – Ховд	1321	5
2	Ховд - Хар ус нуур	29	
3	Ховд аймгийн нутгаар	150	
<b>Дүн</b>		<b>1500</b>	<b>5</b>

Туршлага судлах аяллын маршрутад зарцуулагдах хөрөнгө

Д/д	Зардал	Зарцуулах	Нэгж бүрийн өртөг	Нийт өртөг
1	2	3	4	5
1	Шатахуун	3000/100*18=540 л	3 980 төг	2 149 200
2	Шатахуун	3000/100*18=540 л	3 980 төг	2 149 200
3	Томилолт	7 хүн * 5 хоног =35	118 000төг	4 130 000
4	Гарын бэлэг	1 000 000	-	1 000 000
<b>Дүн</b>				<b>9 428 400</b>

Ажлын хэсгийн гишүүд

Д/д	Гишүүд	Албан тушаал	Утас
1	2	3	4
1	М.Батчимэг	НБХ-ийн дарга	99798949
2	Ё.Хулан	НБХ-ийн мэргэжилтэн	99576956
3	А.Оюунжаргал	НБХ-ийн мэргэжилтэн	88012206
4	Г.Давааням	ХБТХОХ-ийн дарга	99071963
5	М.Цэрэнчимэд	ХБТХОХ-ийн мэргэжилтэн	99124604
6	Г.Бямбажаргал	ХБТХОХ-ийн мэргэжилтэн	99713147
7	С.Сүхбаатар	ХБТХОХ-ийн мэргэжилтэн	95244284
8	Г.Алдармөнх	СУГ-ын дарга	99108725
9	Н.Мөнгөнтуяа	ХЖТ-ын дуучин	89698937
10	Н.Отгонбямба	ЭМГ-ын жолооч	99349957
11	Д.Энхтүвшин	ГХБХБГ-ын жолооч	99820248